| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 1,547.0 | 2,707.0 | 1,160.0 | 0.5 |
| ЗДТГ | 35,532.8 | 48,926.6 | 13,393.8 | 9.5 |
| Соёл | 10,675.3 | 9,672.0 | -1,003.3 | 1.9 |
| ЭМТ | 22,903.5 | 35,767.2 | 12,863.7 | 6.9 |
| ОНХС | 223,500.0 | 223,500.0 | 0.0 | 43.2 |
| ЕБС | 118,900.2 | 114,131.3 | -4,768.9 | 22.1 |
| Цэцэрлэг | 75,521.8 | 82,175.6 | 6,653.8 | 15.9 |
| **НИЙТ ДҮН** | **488,580.6** | **516,879.7** | **28,299.1** | **100.0** |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 680,666.5 мянган төгрөгийн бараа материалын 633,332.2 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 35,547.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, 11,786.6 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар авсан байна. Тайлант онд ЗДТГ 21,372.0 мянга, ИТХ 160.0 мянга, Эрүүл мэндийн төв 11,306.6 мянга, ЕБС 4,654.7 мянга, хүүхдийн цэцэрлэг 977.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 671,316.5 | Хасагдсан | 652,367.4 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 623,982.2 | Худалдсан, зарцуулсан | 626,022.1 |
| Хандиваар | 11,786.6 | шилжүүлсэн | |
| Шилжүүлсэн авсан | 35,547.7 | | - |
| бусад | - | бусад | 26,345.3 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,669,141.5 мянга, эцсийн үлдэгдэл 5,229,220.0 мянган төгрөг болж 560,078.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 4,587,645.5 | 5,143,689.0 | 556,043.5 | 98.4 |
| Барилга байгууламж, орон сууц | 3,238,610.0 | 3,599,886.60 | 361,276.6 | 68.8 |
| Тээврийн хэрэгсэл | 294,366.4 | 306,741.39 | 12,375.0 | 5.9 |
| Машин тоног төхөөрөмж | 592,114.6 | 750,145.75 | 158,031.2 | 14.3 |
| Тавилга эд хогшил | 283,193.0 | 304,450.11 | 21,257.1 | 5.8 |
| Номын фонд | 52,936.6 | 56,040.28 | 3,103.7 | 1.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 126,424.9 | 126,424.91 | 0.0 | 2.4 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 81,496.0 | 85,531.0 | 4,035.0 | 1.6 |
| Программ хангамж | 2,080.0 | 2,080.00 | 0.0 | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 79,416.0 | 83,451.00 | 4,035.0 | 1.6 |
| **НИЙТ ДҮН** | 4,669,141.5 | 5,229,220.0 | 560,078.5 | 100.0 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 618,956.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 75.8 хувь буюу 469,518.7 мянган төгрөгийг хөрөнгийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна Үүнд ЗДТГ нь орон нутгийн хөгжлийн сангаас 79,818.4 мянга,

аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянга, хандиваар 3,000.0 мянга, Хүүхдийн цэцэрлэг нь сумын ЗДТГ-ын 2,000.0 мянга, Дэлхийн зөн ОУБ-аас 650.0 мянга, Эрүүл мэндийн төв нь аймгийн ЭМГ-аас 5,896.5 мянга, сумын ОНХС-аас 19,000.0 мянга, Мобайл технологи ОУ-ын төслийн байгууллагаас 11,920.2 мянга, хандиваар 30,000.0 мянга, Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн ЗДТГ-аас 5,605.0 мянга, Дэлхийн зөн ОУБ-аас нийлүүлсэн 6,264.2 мянга, БСУГ-аас олгосон 2,168.7 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 41,117.7 | 50,302.7 | 9,185.0 | 1.0 |
| ЗДТГ | 1,780,665.3 | 1,893,878.8 | 113,213.5 | 36.2 |
| Соёл | 375,887.3 | 624,929.5 | 249,042.2 | 12.0 |
| ЭМТ | 507,924.5 | 696,162.0 | 188,237.5 | 13.3 |
| ЕБС | 1,273,482.3 | 1,284,251.3 | 10,769.0 | 24.6 |
| Цэцэрлэг | 690,064.4 | 679,695.7 | -10,368.7 | 13.0 |
| **НИЙТ ДҮН** | **4,669,141.5** | **5,229,220.0** | **560,078.5** | **100.0** |

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тухайн онд 149,437.4 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 73,730.8 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 130,393.4 мянга, бусад байдлаар 265,394.5 төгрөгийг шилжүүлэн авсан байна

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 137 дугаар тогтоолоор ЕБС нь 43,498.9 мянга, хүүхдийн цэцэрлэг 15,378.7 мянган төгрөгийн тус тус акталсан байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | **618,956.15** | Хасагдсан | **58,877.59** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 149,437.40 | Худалдсан | |
| Хандиваар | 73,730.86 | Акталсан | 58,877.59 |
| Шилжүүлэн авсан | 130,393.39 | Шилжүүлсэн | |
| бусад | 265,394.50 | Бусад | |

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 34,360.3 мянга, эцсийн үлдэгдэл 194,540.8 мянган төгрөг болж 160,180.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 34,360.3 | 194,540.8 | 160,180.5 | 100.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 4,371.5 | 24,415.0 | 20,043.5 | 12.6 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,567.9 | 100,145.1 | 98,577.2 | 51.5 |
| Байгууллагад төлөх өглөг | 28,420.9 | 69,980.6 | 41,559.7 | 36.0 |
| Дүн | 34,360.3 | 194,540.8 | 160,180.5 | 100.0 |

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 194,540.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын Эрүүл мэндийн төвийн өглөг 172,978.4 мянган төгрөг буюу 88.9 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 21,366.9 мянган төгрөг буюу 11 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.Энэ нь орон нутгийн хөгжлийн

сан нь газар тариалангийн тоног төхөөрөмжийг лизингийн зээлээр авсантай холбоотой бөгөөд 2024 он хүртэл төлөх гэрээтэй байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 303.9 | 0.2 | (303.7) | 0.0 |
| ЗДТГ | 72.1 | 108.6 | 36.5 | 0.1 |
| Соёл | 36.7 | 36.7 | 0.0 | 0.0 |
| ЭМТ | 5,507.2 | 172,978.4 | 167,471.2 | 88.9 |
| ОНХС | 28,366.9 | 21,366.9 | (7,000.0) | 11.0 |
| ЕБС | 73.4 | 50.0 | (23.4) | 0.0 |
| ДҮН | 34,360.2 | 194,540.8 | 160,180.6 | 100.0 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,318,877.2 мянга, эцсийн үлдэгдэл 4,855,250.3 мянган төгрөг болж, 536,373.1 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,653,537.0 | 1,653,537.0 | - | 34.1 |
| Өмч: - төрийн | 1,653,537.0 | 1,653,537.0 | 0.0 | 34.1 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 1,166,728.7 | 1,703,101.8 | 536,373.1 | 35.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,498,611.5 | 1,498,611.5 | - | 30.9 |
| **Дүн** | 4,318,877.2 | 4,855,250.3 | 536,373.1 | 100.0 |

Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс 536,373.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 536,373.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн хуралдаанаар 2/02 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 53,000.0 мянга, хүү торгуулийн орлогыг 20,000.0 мянга, нийт 96,900.0 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **1.Татварын орлого** | 76,900.0 | 145,691.3 | 68,791.3 | 189.5 |
| **ИОТХ** | 12,000.0 | 36,366.5 | 24,366.5 | 303.1 |
| **Бууны татвар** | 2,700.0 | 1,620.0 | (1,080.0) | 60.0 |
| **Улсын тэмдэгтийн хураамж** | 1,500.0 | 3,959.2 | 2,459.2 | 263.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Хадгаламжийн хүүгийн орлого** | 41,000.0 | 50,461.9 | 9,461.9 | 123.1 |
| **Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого** | 3,000.0 | 28,697.2 | 25,697.2 | 956.6 |
| **Газрын төлбөр** | 7,200.0 | 10,567.5 | 3,367.5 | 146.8 |
| **Хог хаягдлын үйлчилгээний хураамж** | 9,000.0 | 13,909.1 | 4,909.1 | 154.5 |
| **бусад татвар** | 500.0 | 110.0 | (390.0) | 22.0 |
| **2.Татварын бус орлого** | 20,000.0 | 53,601.0 | 33,601.0 | 268.0 |
| **2.1.Хүү торгуулийн орлого** | 20,000.0 | 53,601.0 | 33,601.0 | 268.0 |
| **Нийт дүн** | 96,900.0 | 199,292.3 | 102,392.3 | 205.7 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 68,791.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 24,366.5 мянга, улсын тэмдэгтийн хураамж 2,459.2 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 9,461.9 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 25,697.2 мянга, газрын төлбөр 3,367.5 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 4,909.1 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин бууны албан татвар 60.0 хувь буюу 1,080.0 мянга, бусад татвар 22 буюу 390.0 мянган төгрөгийн орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 350.0 мянга, соёлын төв 1,500.0 мянган төгрөгийн орлогоос 250.0 мянган төгрөгийн орлого тус тус орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 70,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 77,592.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,633,058.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,381,869.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 2,210,380.2 урсгал зардалд зарцуулсан бол 171,488.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

## 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор нийт 2,478,836.8 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 79,891.20 | 70,632.60 | 9,258.60 |
| Засаг даргын Тамгын газар | 506,461.40 | 368,225.60 | 138,235.80 |
| Сургууль | 843,252.40 | 665,153.60 | 178,098.80 |
| Цэцэрлэг | 443,376.10 | 422,258.80 | 21,117.30 |
| Эрүүл мэндийн төв | | 497,837.50 | -497,837.50 |
| Соёлын төв | 143,336.60 | 101,062.10 | 42,274.50 |
| Сум хөгжүүлэх сан | | 80,000.00 | -80,000.00 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 273,666.60 | -273,666.60 |
| Нийт дүн | 2,016,317.70 | 2,478,836.80 | -462,519.10 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор анх 2,478,836.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.23-ний өдрийн 4/01 дугаар тогтоолоор 136,304.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 17,917.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,633,058.4 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,482,884.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 160,666.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 509,664.1 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 96,900.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 89,500.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 32,843.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 260,600.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч,орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 65,417.3 мянган төгрөгөөр илүү, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 4,729.9 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн ба улсын төсөвт 19,608.2 мянга, орон нутгийн төсөвт 7,049.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Улсын төсөвт төвлөрүүлсэн | ОН төсөвт төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| ИТХ | 97,132.6 | 95,975.3 | 1,157.3 | 98.8 | | 1157.3 |
| ЗДТГ | 403,425.6 | 403,238.5 | 187.1 | 100.0 | | 187.1 |
| Сургууль | 756,025.7 | 752,024.7 | 4,001.0 | 99.5 | 3,963.6 | |
| Цэцэрлэг | 356,508.3 | 337,066.7 | 19,441.6 | 94.5 | 10,897.4 | |
| Соёлын төв | 99,562.1 | 93,857.1 | 5,705.0 | 94.3 | | 5705.0 |
| Хүн эмнэлэг | 505,437.5 | 505,419.2 | 18.3 | 100.0 | 4,747.3 | |
| СХСан | 94,000.0 | 77,592.8 | 16,407.2 | 82.5 | | |
| ОНХСан | 318,466.6 | 247,588.6 | 70,878.0 | 77.7 | | |
| Нийт дүн | 2,630,558.4 | 2,512,762.8 | 117,795.6 | 95.5 | 19,608.2 | 7,049.4 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 4,001.0 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 19,441.6 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 70,878.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 237,360.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 284,695.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 24,318.4 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 21,737.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 417,928.8 мянган төгрөгийг зарцуулж 58,070.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | ЕБС | Цэцэрлэг | ЭМТ | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 1,000.00 | 113,443.55 | 33,430.48 | 8,504.01 | 365,677.23 | 522,055.27 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000.00 | 113,443.55 | 33,430.48 | 8,504.01 | 80,982.23 | 237,360.27 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | | | | 284,695.00 | 284,695.00 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | 1,000.00 | 55,386.00 | 33,430.48 | 8,504.01 | 365,664.01 | 463,984.50 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.00 | 55,386.00 | 4,488.75 | | 357,054.06 | 417,928.81 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | 24,318.46 | | | 24,318.46 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | | 4,623.27 | 8,504.01 | 8,609.95 | 21,737.23 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | 0.00 | 58,057.55 | 0.00 | 0.00 | 13.22 | 58,070.77 |

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 30,500.0 төгрөгөөр тодотгон баталж, бүрэн зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67.7 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 74 хувийг, 17.0 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг

удаагийн шинжтэй арга хэмжээнд, 9.0 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 107 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,633,058.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,381,869.1 мянган төгрөгийг зарцуулж, 90.4 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 9 нэр төрлийн орлогоор 96,900.0 төгрөг төвлөрүүлэхээс 199,292.3 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 189.5 хувь буюу 68,791.3 сая төгрөгөөр давж биелсэн боловч 2 нэр төрлийн орлого 1,470.0 төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Бөмбөгөр сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЕБСургууль** | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| **Хүүхдийн цэцэрлэг** | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| **ЗДТГ** | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **Соёлын төв** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ЭМТ** | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **8** | **8** | **4** | **4** | **4** | **4** | **0** | **0** | **0** |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагууд зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 477,498.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,154.9 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 6,000.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 459,068.3 мянган төгрөгийн 11 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн* /мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн зөрчил** | | | | | | | | | | |
| **ЕБСургууль** | 5 | 11,337.0 | 1 | 50.0 | | | | | 4 | 11,287.0 |
| **Хүүхдийн цэцэрлэг** | 2 | 2,967.1 | 1 | 2,437.4 | 1 | 529.7 | | | | |
| **ЗДТГ** | 4 | 57,875.2 | | | 3 | 275.2 | | | 1 | 57,600.0 |
| **ОНХСан** | 1 | 238.0 | | | 1 | 238.0 | | | | |
| **ЭМТ** | 3 | 8,667.5 | 2 | 2,667.5 | | | 1 | 6,000.0 | | |
| **СХС** | 1 | 6,232.5 | | | 1 | 6,232.5 | | | | |
| **СТА зөрчлийн дүн** | 16 | 87,317.3 | 4 | 5,154.9 | 6 | 7,275.4 | 1 | 6,000.0 | 5 | 68,887.0 |
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| **ЕБСургууль** | 1 | 36,743.7 | | | | | | | 1 | 36,743.7 |
| **Хүүхдийн цэцэрлэг** | 1 | 3,589.4 | | | | | | | 1 | 3,589.4 |
| **ЗДТГ** | 1 | 57,850.0 | | | | | | | 1 | 57,850.0 |
| **ИТХурал** | 1 | 59,270.0 | | | | | | | 1 | 59,270.0 |
| **Соёлын төв** | 1 | 81,285.1 | | | | | | | 1 | 81,285.1 |
| **ЭМТ** | 1 | 151,443.1 | | | | | | | 1 | 151,443.1 |
| **Нийцлийн аудитын дүн** | 6 | 390,181.3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 6 | 390,181.3 |
| **Нийт дүн** | 22 | 477,498.6 | 4 | 5,154.90 | 6 | 7,275.4 | 1 | 6,000.0 | 11 | 459,068.3 |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 87,317.3 мянган төгрөгийн 16 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 390,181.3 мянган төгрөгийн 6 зөрчил тус тус илэрсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын *"Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"* 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

*Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | хугацаа | төрөл | удаа | хугацаанд нь мэдээлсэн | хугацаа хоцроосон | мэдээлээгүй | Хоцроосон болон хоцроосон мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 12 | 12 | 9 | 2 | 1 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн ба Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг мэдээлээгүй байна. |
| 2 | Хагас жил | 3 | 3 | 3 | | | |
| 3 | Улирал бүр | 2 | 8 | 7 | | 1 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 4 дүгээр улирал |
| 4 | Сар бүр | 5 | 60 | 52 | 7 | 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө,гүйцэтгэл 12 сар, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 1,5,10,12 сарууд, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 12 сар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 12 дугаар саруудад тус тус хугацаа хоцроож байршуулсан. Мөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 12 сарын мэдээллийг мэдээлээгүй байна. |
| 5 | Тухай бүр | 6 | 72 | 68 | 4 | | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 10 сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 10 сар, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 8,10 саруудад хугацаа хоцроож мэдээлсэн. |
| Нийт | | 28 | 155 | 139 | 13 | 3 | |

*Эх сурвалж.Бөмбөгөр сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас*

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын *"Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"* 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Бөмбөгөр сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Бөмбөгөр сумын ЕБС нь тайлант онд улсын төсвөөс 756,025.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 752,024.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 3,963.6 мянган төгрөг буюу төсвийн 0.5 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 40,923.6 мянган төгрөгөөр баталж 40,886.1 мянган төгрөгийг зарцуулж, нийт 8,184.7 мянган төгрөг хэмнэхээс 37.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 8,147.2 мянган төгрөг хэмнээгүй.
- Бөмбөгөр сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 18,167.4 мянган төгрөг батлагдсан төсвийн 20 хувь нь 3,633.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлээр 44.2 мянган төгрөг хэмнэсэн нь төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Бөмбөгөр сумын ЗДТГ нь байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 18,885.3 мянган төгрөгөөр батлагдсан ба гүйцэтгэлээр 18,863.1 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах **зөвлөмжийг** хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 29,835.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн 245 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 20* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 29,835.9 | 3 | 29,835.9 | | | 100.0 |
| Нийт | 3 | 29,835.9 | 3 | 29,835.9 | | | 100.0 |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй 18892.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлж байна.

### 4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт:Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:*Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.*

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор анх 2,478,836.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.23-ний өдрийн 4/01 дугаар тогтоолоор 136,304.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 17,917.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,633,058.4 мянган төгрөг болжээ.

Харин Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 17,917.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.*

3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 477,498.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн " нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

4. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

*Илрүүлэлт:* Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 199,262.3 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 200,238.0 мянган төгрөг буюу 975.7 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:: Сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Хавсралт 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Огноо | Аудитын нэр: | Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2022 | | | БНА-2022/7/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Бөмбөгөр сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар: | | | | |
| 1 | Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна. | - | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Б.Нарангэрэл |
| 2 | Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 17,917.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхад төсөвт тодотгол хийгээгүй байна. | 17,917.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Б.Нарангэрэл |
| 3 | Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 477,498.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | - | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Б.Нарангэрэл |
| 4 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна. | - | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Б.Нарангэрэл |
| 5 | Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 199,262.3 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 200,238.0 мянган төгрөг буюу 975.7 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна. | 975.7 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Б.Нарангэрэл |
| ДҮН | | 18,892.7 | | | |

## 5. Хавсралт 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг даргын Тамгын газар | | 115,725.2 | | | |
| 1 | Орон нутаг хариуцсан нягтлан бодогч Ж.Сэржмядагийн хүүхэд асарсны чөлөөтэй хугацаанд НДШ-ийг мэдээлэхдээ 01 кодоор мэдээлж даатгуулагчаас 96.6 мянган төгрөгийг илүү мэдээлж төсвөөс төлсөн байна. | 96.6 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Тайванжаргал Л.Очирбат |
| 2 | Байгууллагын кассын дансанд 2021.12.23-нд 53.6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл гэж шилжүүлж нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлээгүй кассын үлдэгдлээр тайлагнаагүй байна. | 53.6 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Тайванжаргал Л.Очирбат |
| 3 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 1,250.0 мянган төгрөгийн тэтгэмж, шагнал урамшуулал олгохдоо ХАОАТ-ыг суутган тооцоогүй байна. | 125.0 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Тайванжаргал Л.Очирбат |
| 4 | Тус байгууллага нь 2021 онд нийт 563,504.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 51 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4 гүйлгээний 57,850.0 мянган төгрөгийн мэдээлээгүй байна. | 57,850.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Тайванжаргал Л.Очирбат |
| 5 | Тавилга эд хогшилд бүртгэлтэй 57,600.0 мянган өртөгтэй 2 ширхэг эрчим хүчний моторны үнэнд 10,000.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дансанд 2010.05.04-нд иргэн Бямбацэрэн бэлнээр тушаасан байна. | 57,600.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Тайванжаргал Л.Очирбат |
| Ерөнхий боловсролынсургууль | | 48,080.7 | | | |
| 1 | Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 50.0 мянган төгрөгийг буруу илэрхийлсэн байна. | 50.0 | Санхүүгийн тайланд залруулсан | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |
| 2 | Түлш халаалтын зардлаас худалдан авсан нүүрсний шатахууны зардал болох 2,979.5 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан. | 2,979.5 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |
| 3 | Интернет, шуудан холбоо, лиценз, усны шинжилгээ, аудитын төлбөр, бусад зардлын 5,310.3 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн харилцахын данснаас авлага өглөгийн хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн байна. | 5,310.4 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |
| 4 | Үйлчлэгч ажилтай С.Мөнхөө нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно" гэж заасаны дагуу 8,182.2 мянган төгрөгийн тэтгэмж авсан байхад байгууллагын дарга 2021.09.02-ны өдрийн Б/22 дугаартай тушаал гаргаж цалингийн зардлаас нэг сартай тэнцэх 520.0 мянган төгрөгийн тэтгэмж төсвөөс нэмж олгосон байна. | 520.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |
| 5 | Цалин, НДШ-ийн тохируулах бичилтийг сар бүр буруу хийснээс жилийн эцэст 2,477.2 төгрөгийг үр дүнгийн тайланд буруу илэрхийлсэн байна. | 2,477.2 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |
| 6 | Тус байгууллага нь 2021 онд нийт 807,660.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 779,063.7 мянган төгрөгийн 142 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 28,596.4 мянган төгрөгийн 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 28,596.5 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Тайлант онд улсын төсвөөс 756,025.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 752,024.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 3,963.6 мянган төгрөг буюу төсвийн 0.5 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 40,923.6 мянган төгрөгөөр баталж 40,886.1 мянган төгрөгийг зарцуулж, нийт 8,184.7 мянган төгрөг хэмнэхээс 37.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 8,147.2 мянган төгрөг хэмнээгүй | 8,147.3 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Л.Насантогтох Б.Ганболд |
| ИТХ | | 59,270.0 | | | |
| | Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 28 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын 10 гүйлгээний 59270.0 мянган төгрөгийн хугацаа хоцроож байршуулсан байна. | 59,270.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Мэндбаяр Л.Очирбат |
| Сум хөгжүүлэх сан | | 6,232.5 | | | |
| | Сум хөгжүүлэн сангаас 2019 онд авсан 3.188.5 мянга, 2020 онд 3.044.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн өртэй,зээлдэгчид зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй байна. | 6,232.5 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Ж.Сэржмядаг |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 238.0 | | | |
| | Ямаа ангилалтаар ажилласан ажилчдад олгосон урамшуулал 1800.0 мянга, малын тэжээл 440.0 мянга,эм тарианы зардалд 140.0 нийт 2380.0 төгрөгийг ХХОАТ суутган тооцоогүй олгосон Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дэх заалтыг зөрчсөн байна. | 238.0 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ Ж.Сэржмядаг |
| Эрүүл мэндийн төв | | 160,110.7 | | | |
| 1 | 2021 оны 9-р сард "Санаснаар арвижих баялаг" ХХК-иас багийн эмчийн албан хэрэглээний зориулалтаар худалдан авсан 6,000.0 мянган төгрөгийн мотоциклийн эзэмшлийн гэрчилгээ байгууллагын нэр дээр шилжээгүй байна. | 6,000.0 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Оюундалай Ж.Гандалай |
| 2 | Тайлант хугацаанд элэгдлийн зардлыг 2.306.7 мянган төгрөгөөр дутуу, НДШ-ийн төлөгчийн даатгуулагчийн төрлийг зөрүүтэй сонгосноос НДШ-ийн өглөг 154.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан ба дээрх зөрүүний улмаас ХХОАТ-ыз өглөг 206.1 мянган төгрөгөөр дутуу тусгагдсан байна. | 2,667.6 | Санхүүгийн тайланд залруулсан | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Оюундалай Ж.Гандалай |
| 3 | Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс нийт 151.443.1 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 151,443.1 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Оюундалай Ж.Гандалай |
| Хүүхдийн цэцэрлэг | | 6,556.5 | | | |
| 1 | Нягтлан бодогчийн 1,3-р улирлын үр дүнгийн урамшуулал цалинг үндсэн орон тооны ажилтны цалингаас бодож 529.7 мянган төгрөгийг илүү олгосон | 529.7 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Цэцгээ Б.Ганболд |
| 2 | Даатгуулагчийн төлөх НДШ-ийн 23.62.4 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас төлж тайлагнасан, цахилгааны зардалд төлсөн 75.0 мянган төгрөгийг цалингийн зардалд хаасан байна. | 2,437.4 | Санхүүгийн тайланд залруулсан | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Цэцгээ Б.Ганболд |
| 3 | Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төсвөөр 18.167.4 мянган төгрөг батлагдсан ба хийт батлагдсан төсвийн хувь нь 3.633.6 мянган төгрөг байна. Тус онд 44.2 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна. | 3,589.4 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Цэцгээ Б.Ганболд |
| Соёлын төв | | 81,285.1 | | | |
| | Бөмбөгөр сумын Соёлын төв нь 2021 онд 111,557.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 30,272.2 мянган төгрөгийн 122 мэдээллийг хугацаандаа байршуулж 81,285,1 мянган төгрөгийн 27 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна. | 81,285.1 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Р.Наранбат Л.очирбат |
| | Нийт дүн | 477,498.6 | | | |